

# **ХАНБОГД СУМЫН ЗАХИРГАА, МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Ханбогд сум

Их булаг

2015 оны 2 дугаар сарын 5

Та бүхэнд Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (CAO) байгууллагын оролцоотой маргааныг шийдвэрлэх Малчдын төлөөлөгчид болон “Оюу толгой” компанийн хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын тухай мэдээлдэг билээ. Уулзалт 2015 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Ханбогд сумын Техникийн сургалтын төвд хийгдсэн бөгөөд тойм мэдээг та бүхэнд хүргүүлж байна.

Энэхүү уулзалтын гол зорилго нь орон нутгийн захиргаа, малчдын төлөөлөл болон “Оюу толгой” компани цаашид CAO байгууллагын уулзалтаар шийдвэрлэсэн асуудлыг “Гурван талт хамтарсан зөвлөл” байгуулан хэрэгжүүлэх, түүний дүрмийн төсөл боловсруулах мөн гомдлын асуудлын шийдлийн явц хэлэлцэх байлаа.

Уулзалтыг уламжлал ёсоор Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (CAO)-ий газрын зуучлагч чиглүүлж, Ханбогд сумын засаг дарга Т.Буян-Өлзий болон Ханбогд сумын ИТХ-ын дарга Х.Нэхийт, Оюу Толгойн Хяналт ТББ малчдын зөвлөхөөр мөн Австралийн Күинслэндийн их сургуулийн Уул уурхай дахь Нийгмийн хариуцлагын төвийн доктор Д. Бямбажав ажиглагчаар оролцов.

Уулзалтын үр дүнд талууд:

- Орон нутгийн засаг захиргаа, малчдын төлөөлөл болон “Оюу толгой” компанийн Хамтарсан зөвлөлийн дүрмийн төсөл боловсруулав.
- Бор Овоогийн шинэ задгайн байршлыг гурван тал очиж үзэхээр болов.
- Хамтарсан зөвлөл ИТХ-ын тогтоолоор байгуулж, Санамж бичгийн хүрээнд ажиллахаар болов.

Малчдын төлөөлөл, Орон нутгийн засаг захиргаа, болон “Оюу толгой” компаниас бүрдсэн Хамтарсан зөвлөлийн анхны хурлыг 3 дугаар сарын сүүлээр хийхээр тохирлоо.

Ханбогд сумын захиргаа  
Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид  
Оюу Толгой ХХК